



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 590

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн Агроэкологи бизнесийн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 16 нэрийн нийт 9,870,365.00 (есөн сая найман зуун далан мянга гурван зуун жаран таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн Агроэкологи бизнесийн сургуулийн захирал Л.Пүрвээд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн
590 дугаар тогтоолын хавсралт

**ХААИС ХАРЬЯА УРГАМАЛ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХҮРЭЭЛЭН АГРОЭКОЛОГИ
БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ, (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	МТЗ-82 тракторын хөдөлгөөнт иж бүрэн зүсмэл төхөөрөмж	ш	1	2002-12-20	1,809,000.00	1,809,000.00
2	Грануламетр	ш	1	2012-12-21	350,000.00	350,000.00
3	Компрессор	ш	1	2012-12-21	1,200,000.00	1,200,000.00
4	Шороо ангилагч	ш	1	2012-12-21	400,000.00	400,000.00
5	Геометрийн хуулиудыг судлах багаж	ш	1	2011-06-02	540,000.00	540,000.00
6	Гэрлийн дисперсийг судлах багаж	ш	1	2011-06-02	550,000.00	550,000.00
7	Гэрлийн хуулиудыг судлах багаж	ш	1	2011-06-02	275,000.00	275,000.00
8	Математик дүүжин судлах багаж	ш	1	2011-06-02	257,000.00	257,000.00
9	Холлын эффекттийг судлах багаж	ш	1	2011-06-02	985,000.00	985,000.00
10	Хувийн цах цэнэг тодорхойлох багаж	ш	1	2011-06-02	410,000.00	410,000.00
11	Хувьсах гүйдлийг судлах багаж	ш	1	2011-06-02	130,000.00	130,000.00
12	Цах гүйдлийн хуулийг судлах багаж	ш	1	2011-06-02	653,000.00	653,000.00
13	Цахилгаан статик орон багаж	ш	1	2011-06-02	384,000.00	384,000.00
14	Анжис	ш	1	2004-09-30	430,000.00	430,000.00
15	Агаарын даралтын мэдрүүр багаж	ш	1	2008-12-31	1,381,865.00	1,381,865.00
16	Тог баригч APC	ш	1	2013-11-21	115,500.00	115,500.00
НИЙТ ДҮН						9,870,365.00
						(есөн сая найман зуун далан мянга гурван зуун жаран тав)